



WHITE PAPER 2.0

ADMC

МЭДЭГДЭЛ

Энэхүү баримт бичиг нь зөвхөн мэдээллийн чанартай бөгөөд хөрөнгө оруулагчдад ADMC 2.0 койны үйл ажиллагаа, хэтийн төлөвлөгөө, койны онцлог зэргийг танилцуулах зорилготой болно.

Уг танилцуулга дээрх тоо баримт, мэдээлэл, түүний агуулга нь ADMC 2.0 койныг худалдан авах санал, захиалга хийх уриалга биш ба хувь хүн, аж ахуйн байгууллагуудад хөрөнгө оруулалтын зөвлөгөө болох баримт бичиг биш болно.

Алтандорнод Монгол” ХХК-иас гаргасан койн нь крипто хөрөнгийн зах зээлд өөрийн үйл ажиллагаа ирээдүйд хэрэгжүүлэх төслүүд, бодит хөрөнгөд суурилсан болон бусад хөрөнгө шинжүүдийг агуулсан шинэ төрлийн бүтээгдэхүүн болох тухайн танилцуулга юм.

ADMC 2.0 нь “Алтандорнод Монгол” ХХК-иас 2021 оны 11 сард ADMC койны шууд үргэлжлэл бөгөөд технологийн хувьд сайжруулсан, хөрөнгө оруулалтын нөхцөлийг шинэчилсэн хувилбар юм.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Криптовалютын зах зээл нь онцгой хувьсамтгай бөгөөд үнийн өөрчлөлт нь урьдчилан таамаглахад хэцүү. Койн болон бусад криптовалютын үнэ маш богино хугацаанд огцом өсөх эсвэл огцом буурах боломжтой байдаг. Энэхүү үнийн хөдөлгөөн нь олон хүчин зүйлсээс хамаардаг.

Аюулгүй Байдлын Эрсдэл:

Виртуал хөрөнгийн системүүд нь хакердлага, луйвар, хуурамч схемүүдэд өртөмтгий байж болно. Криптовалютыг аюулгүй хадгалах, итгэмжлэгдсэн платформуудыг ашиглах шаардлагатай.

Зах зээлийн сэтгэлзүй:

Арилжаанд оролцогч болон хөрөнгө оруулагчдын сэтгэл хөдлөл, итгэл үнэмшил нь үнийн өөрчлөлтөд ихээхэн нөлөөлдөг. Жишээ нь, зах зээлд эерэг мэдээ тархах үед хөрөнгө оруулагчид койн худалдан авах эрмэлзэлтэй болж, үнийн өсөлтөд нөлөөлж болдог. Эсрэгээрээ, сөрөг мэдээ, айдас, эргэлзээний улмаас үнийн уналт бий болдог.

Спекуляци (Тохиолдлын Худалдаа): Зарим криптовалютуудын үнэ нь тодорхой эдийн засгийн үндэслэлгүйгээр огцом өсөх эсвэл буурах тохиолдол гардаг. Энэ нь ихэвчлэн спекуляцийн үр дүнд буюу худалдаачид зах зээлд түргэн орж гарах хүсэлтэй байхаас шалтгаалдаг. Ийм нөхцөл байдалд койны үнэ нь бодит зах зээлийн үнэлгээгээ алдаж, хөөсрөл үүсгэх, эсвэл үнийн уналт гарч болох эрсдэлтэй.

Иймээс Виртуал хөрөнгийн арилжаанд оролцохдоо сэтгэл хөдлөлд бус зөвхөн тоон болон судалгаанд үндэслэсэн шийдвэр гаргах нь танийг учирч болох аливаа эрсдлээс сэргийлэхийг анхаарна уу.

ВИРТУАЛ ХӨРӨНГӨ ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

Октагон Крипто бирж нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын ISO 27001:2013 олон улсын стандартыг нэвтрүүлээд хоёр дахь жилдээ хэрэгжүүлээд явж байна. Бид уг стандартын хүрээнд байгууллагын дотоод болон гадаад орчинд мэдээллийн аюулгүй байдлын бүрэн хангаж ажиллахын төлөө ажиллаж байна.

Гадаад орчны эрсдэл- Крипто хөрөнгийн үйл ажиллагаа нь шинэ технологи, зах зээлийн шинэ хандлага тул дэлхий нийтэд тулгарч буй дараах эрсдэлүүд ихээхэн нөлөөтэй.

- Дэлхийн зах зээл дэх крипто хөрөнгийн үнэ ханшийн хэлбэлзэл
- Хууль эрх зүйн зохицуулалтын ойлгомжгүй байдал
- Хүлээн зөвшөөрөх цар хүрээ
- Аюулгүй байдал болон луйвар
- Крипто биржүүдийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүд
- Технологийн эрсдэлүүд
- Байгаль орчны эрсдэл

Дотоод орчны эрсдэл- Монгол Улсын хувьд үйл ажиллагаа явуулж байгаа крипто хөрөнгийн хувьд дараах эрсдэлүүд тулгарч болзошгүй гэж үзэж байна.

- Хууль эрх зүйн орчин
- Крипто хөрөнгийн зах зээлийн талаарх сөрөг мэдээлэл, хандлага
- Аюулгүй байдал, хууль бус үйл ажиллагаа, цахим гэмт хэрэг
- Крипто биржүүдийн үйл ажиллагаа
- Үнийн өндөр хэлбэлзэл
- Шимтгэл, хураамжийн асуудал
- Төлөвлөсөн үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлүүд

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Хуулийн этгээдийн оноосон нэр

Алтандорнод Монгол



(976) 7210 9999
(976) 7700 2277

Хуулийн этгээдийн хэлбэр

Хязгаарлагдмал хариуцлагатай
компани (ХХК)



admc@adm.mn

Үйл ажиллагааны чиглэл

Ашигт малтмалын хайгуул,
олборлолт



Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг-15,
Махатма Гандигийн
гудамж-39,
Корпорейт хотел
энд Конвеншн
центр

КОЙН ГАРГАГЧЫН ТАНИЛЦУУЛГА

“Алтандорнод Монгол” ХХК нь 1997 онд байгуулагдсан бөгөөд алтны хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын хэмжээний томоохон уул уурхайн компаниудын нэг юм. 2011 оны 9 дүгээр сард үндэсний хөрөнгө оруулагчид татвар болон бусад өр зээлийн хамт “Алтандорнод Монгол” ХХК-ийг хамаарал бүхий бусад компаниудтай нь худалдан авч 300 орчим сая долларын өр төлбөрийг барагдуулсан.

- Алт олборлох үндсэн үйл ажиллагааг явуулахдаа байгаль экологийн асуудлыг эн тэргүүнд тавьсаг. Байгалийн нөхөн сэргээлт хийгдэлгүй орхигдсон 2000 га талбайг нөхөн сэргээсэн.
- “Алтандорнод Монгол” ХХК нийтдээ 3500 ажлын байр бий болгосон.
- Мөн үл хөдлөх хөрөнгө, үйлчилгээний салбарт олонд танигдсан бренд болох “Корпорейт” зочид буудлын сүлжээг үүсгэн байгуулсан.

“Алтандорнод Монгол” ХХК АDМC 2.0 төслийн хүрээнд 2023 онд шинэчилсэн төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд дараах ажлуудыг төлөвлөөд байна.

- ОУ-н жишигт нийцсэн крипто бирж хөгжүүлэлт,
- Койны цогц удирдлага (HODL, BURN, АDМC 2.0 dao, NFT, DeFi exchange, TIER1 exchange),
- Төлбөр тооцооны хөтөлбөрүүдийг хийхээр төлөвлөж байна.

ТОКЕНЫ МЭДЭЭЛЭЛ

Койны нэр:	Altan Dornod Mongol Coin
Койны тикер:	ADMC
Койн хаяг:	https://bscscan.com/token/0x19e2ee6be1077ab4b24ff49ea635acc23aa7430e
Койн гаргагч:	Алтан Дорнод Монгол ХХК
Койны стандарт:	BEP20
IEO Ханш:	1₮
Нийт койны тоо ширхэг:	495,000,000,000 ADMC
Олборлолт:	Олборлолт буюу майнинг хийх боломжгүй
Бүртгэлтэй бирж:	idax.exchange, capex.mn, octagon.mn
Фейсбүүк:	www.fb.com/ADMCOINMN
Инстаграм:	www.instagram.com/admcoinmn/
Телеграм:	t.me/ADMCoinmn

ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН

05/11/2021

ADMC ICO зарлалаа

18/11/2021

ADMC ICO хаагдлаа

01/12/2021

ByDEP биржийг нээлээ
ADMC хоёрдогч арилжаа эхэллээ

10/12/2021

CAPEX бирж дээр арилжаалагдаж эхэллээ

17/12/2021

DAX бирж дээр арилжаалагдаж эхэллээ

20/12/2021

ADMC Hodl хөтөлбөр зарлагдлаа
ADMC Төлбөр тооцоо хөтөлбөр эхэллээ

01/03/2022

Харилцагчдын хүсэлтээр койныг анхны үнээр буцаан худалдан авах ажиллагааг дуусгасан.

28/03/2022

ADMC хөрөнгө оруулалтын төслийг эхлүүллээ.

06/05/2022

CRIPTO PLANET арга хэмжээг зохион байгуулсан.
Subedei NFT төслийг эхлүүллээ.

07/05/2022

6 сарын Ходлын өгөөжөө тараасан.

18/06/2022

NFT SUMMIT 2022 арга хэмжээг зохион байгуулсан.

24/08/2022

“Octagon” Крипто хөрөнгийн биржийн төслийг эхлүүлэхээр боллоо.

01/03/2023

“МӨНГӨЖҮҮЛЭХ” Хөтөлбөрийн өгөөж тараагдлаа

2023-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

BURN-ADMC койныг гаргах үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотой зарагдаагүй, буцаан худалдан авсан койныг шатаах арга хэмжээг авч койны нийлүүлэлтийг одоо эргэлтэд байгаа болон ходлеруудын өгөөжийн түвшинд хадгалах бодлого баримтална.

INVESTMENT- Эх үүсвэрийг боломжит өндөр өгөөж бүхий хөрөнгө оруулалтад байршуулж үр дүнг койн эзэмшигчдэд хүртээх, койны үнэ цэнийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулна.

PROJECTS- Одоо хэрэгжүүлж буй HODL хөтөлбөр, NFT төслүүдийг үргэлжлүүлэхээс гадна Burn, NFT, payment хөтөлбөрүүдийг шинээр хэрэгжүүлнэ.

PROJECT & PROGRAM- Одоо хэрэгжүүлж буй HODL хөтөлбөр, NFT төслүүдийг үргэлжлүүлэхээс гадна Burn, NFT, payment хөтөлбөрүүдийг шинээр хэрэгжүүлнэ.

“Octagon-ADMC” крипто бирж нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Fireblocks” аюулгүй байдлын платформтой хамтран ажиллаж байгаа. Тус платформын сүлжээ нь цаг хугацаа хэмнэхийн тулд алдаа гарах магадлал өндөртэй гар ажиллагаатай процессоос зайлсхийж, харилцагч талуудын хооронд хадгаламжийн дундын хаягийг автоматаар баталгаажуулдаг. Тиймээс Fireblocks-ын тусламжтайгаар “Octagon-ADMC” бирж нь илүү хурдан, олон сонголттой, найдвартайгаар тасралтгүй ажиллах боломжтой болно. Ингэснээр технологийн хамгийн сүүлийн үеийн ололтод тулгуурласан, цаг хугацаа орон зайнаас үл хамаарсан, хамгийн найдвартай биржийг бүтээх ажил маань дахин нэг томоохон давуу талтай болж байгаагаас гадна төслийн бусад ажлууд хэвийн үргэлжилж байна.

ТОКЕНОМИКС

Корпорейт сүлжээ зочид буудлуудын 16 төрлийн үйлчилгээнд токен ашиглах үйлчилгээг нэвтрүүлснээр токен эзэмшигчдийг зах зээлийн эрсдлээс хамгаалах, ханшийн тогтвортой байдлыг хангах зорилготой.

Анхны үнээр токенийг эргэлтэнд оруулах үйлчилгээг хэрэгжүүлсээр байна.

1. Ханшийн Тогтвортой Байдал

- Үнэлгээний Тогтвортой Байдал: Зах зээлийн хэлбэлзэлд өртөхгүйгээр анхны үнээр токеныг ашиглах нь ханшийн тогтвортой байдлыг хангана.
- Итгэлцэл: Ханшийн тогтвортой байдал нь токен эзэмшигчдийн зах зээлд итгэлтэй оролцоход нөлөөлөх ба төслийн урт хугацааны амжилтыг хангах боломжийг олгоно.

2. Токены Эргэлт

- Эргэлтийн Систем: Анхны үнээр токеныг эргэлтэнд оруулах боломжтой болсноор урт хугацааны эргэлтэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Эргэлтийг идэвхжүүлж, эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлснээр, токены хэрэглээний боломжийг өргөжүүлнэ.
- Хэрэглээ: АДМС токенийг Корпорейт сүлжээ зочид буудлуудын үйлчилгээний төлбөр тооцоонд нэвтрүүлэх нь токеныг бодит хэрэглээнд оруулж, ашиглалтын ач холбогдлыг нэмэгдүүлнэ.

3. Зах Зээлийн Эрсдэлээс Хамгаалах

- Эрсдэлээс Хамгаалах Механизм: Төлбөрт тооцуулах үйлчилгээ нь токеныг зах зээлийн хэлбэлзлээс хамгаалж, үнэ цэнийг хадгална. Энэ нь токен эзэмшигчдэд зах зээлийн өөрчлөлтүүдээс үл хамааран тогтвортой ашиг олох боломжийг олгоно.
- Ханшийн Тогтвортой Байдал: Зах зээлийн хэлбэлзэлд өртөхгүйгээр анхны үнээрээ токеныг эргэлтэнд оруулах боломж нээлттэй байснаар зах зээлийн эрсдэлээс хамгаалагдсан, баталгаатай орлого, ашиг олох боломжтой.

Токены хэрэглээ

Төслийн хүрээнд токenuудыг дараах 16 төрлийн үйлчилгээнд ашиглах боломжтой:

Хурлын танхим, концерт заал

- Хурал зөвлөгөөн, хурим, уулзалт зохион байгуулахад токен ашиглах

Өрөө захиалга

- Токен ашиглан зочид буудлын өрөө захиалах.

Ресторан, кафе

- Зочид буудлын рестораны болон кафены үйлчилгээ авах.


Фитнес төв, усан бассейн

- Спорт заал, фитнес төвийн үйлчилгээ.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

АДМС төслийн зүгээс хүсэлт гаргасан хөрөнгө оруулагчдаас өөрсдийн гаргасан токенийг анхдагч зах зээлд гарснаас эхлэн 3 сарын дотор, анх зарласан үнээр нь буцаан худалдан авсан. Төслийн баг энэхүү ажлыг хэрэгжүүлэх шийдвэр гаргаснаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулагчдад зах зээлийн нөхцөл байдал болон ирээдүйд гарч болзошгүй эрсдлийг сайтар үнэлж, өөрсдийн шийдвэрийг дахин нягталж үзэх боломжийг олгосон. Тус арга хэмжээ нь төслийн багын шийдвэр, хөрөнгө оруулагчдын хүсэлт болон зөвшөөрлөөр учирч болзошгүй зах зээлийн гэнэтийн өөрчлөлтөөс татан төвлөрүүлсэн хөрөнгийг хамгаалж, хөрөнгө оруулагчдын санхүүгийн алдагдлыг хязгаарлахад тодорхой үр дүн үзүүлсэн.

Анхдагч зах зээлээс төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт



June 2024